

## ГАРЧИГ

<b>НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ</b> .....	<b>3</b>
1 дүгээр зүйл. Хуулийн зорилт.....	3
2 дугаар зүйл. Иргэний нисэхийн тухай хууль тогтоомж.....	3
3 дугаар зүйл. Иргэний нисэхийн үйл ажиллагааны үндсэн зарчим .....	3
4 дүгээр зүйл. Хуулийн үйлчлэх хүрээ.....	3
5 дугаар зүйл. Хуулийн нэр томъёоны тодорхойлолт .....	3
<b>ХОЁРДУГААР БҮЛЭГ</b> .....	<b>7</b>
<b>ИРГЭНИЙ НИСЭХИЙГ ТӨРӨӨС ЗОХИЦУУЛАХ</b> .....	<b>7</b>
6 дугаар зүйл. Улсын Их Хурлын бүрэн эрх.....	7
7 дугаар зүйл. Засгийн газрын бүрэн эрх .....	7
8 дугаар зүйл. Төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрх.....	7
9 дүгээр зүйл. Сайд, түүний бүрэн эрх .....	9
10 дугаар зүйл. Төрийн захиргааны байгууллагын чиг үүрэг .....	9
11 дүгээр зүйл. Дарга, түүний бүрэн эрх .....	10
12 дугаар зүйл. Эрх шилжүүлэх.....	11
13 дугаар зүйл. Хяналтын байцаагч, түүний бүрэн эрх .....	12
14 дүгээр зүйл. Хяналт, зохицуулалтын үйл ажиллагаа.....	12
15 дугаар зүйл. Нисэхийн мэргэшсэн ажилтны үнэмлэх, гэрчилгээ .....	12
16 дугаар зүйл. Техник үйлчилгээний байгууллага.....	13
17 дугаар зүйл. Сургалтын байгууллага.....	13
18 дугаар зүйл. Хэлэлцэн тохирогч улсын нисэхийн баримт бичиг .....	13
<b>ГУРАВДУГААР БҮЛЭГ</b> .....	<b>13</b>
<b>ИРГЭНИЙ НИСЭХИЙН ДҮРЭМ</b> .....	<b>13</b>
19 дүгээр зүйл. Иргэний нисэхийн дүрмийн зохицуулалт.....	13
20 дугаар зүйл. Иргэний нисэхийн дүрмээр зохицуулах үйл ажиллагаа .....	13
21 дүгээр зүйл. Иргэний нисэхийн дүрмийн шаардлагаас чөлөөлөх.....	14
22 дугаар зүйл. Иргэний нисэхэд гадаад хэл хэрэглэх.....	15
<b>ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ</b> .....	<b>15</b>
<b>АГААРЫН ХӨЛӨГ, ТҮҮНД ХАМААРАХ ҮЙЛ АЖИЛЛАГАА</b> .....	<b>15</b>
23 дугаар зүйл. Агаарын хөлгийн бүртгэл .....	15
24 дүгээр зүйл. Агаарын хөлгийн эзэмшил, өмчлөл .....	15
25 дугаар зүйл. Агаарын хөлгийн нислэгт тэнцэх чадвар.....	16
26 дугаар зүйл. Нислэгийн үйл ажиллагааны төрөл.....	16
27 дугаар зүйл. Агаарын тээврийн үйл ажиллагаа .....	16
28 дугаар зүйл. Ерөнхий зориулалтын нисэхийн үйл ажиллагаа.....	16
29 дүгээр зүйл. Агаарын тээвэрлэгчийн гэрчилгээ .....	17
30 дугаар зүйл. Агаарын тээвэрлэгчийн үүрэг .....	17
31 дүгээр зүйл. Агаарын хөлгийн даргын бүрэн эрх .....	18
32 дугаар зүйл. Нислэгийн үйл ажиллагаанд хориглох зүйлс .....	18
33 дугаар зүйл. Нислэгийн үеийн хэв журам .....	19
<b>ИРГЭНИЙ НИСЭХИЙН ЭДИЙН ЗАСГИЙН ЗОХИЦУУЛАЛТ</b> .....	<b>19</b>
34 дүгээр зүйл. Эдийн засгийн зохицуулалтын дүрэм.....	19
35 дугаар зүйл. Эдийн засгийн зөвшөөрөл .....	19
36 дугаар зүйл. Агаарын тээвэрлэгчийн хариуцлага .....	20
37 дугаар зүйл. Агаарын тээвэрлэгчийн өмчлөл .....	20
38 дугаар зүйл. Гадаадын агаарын тээвэрлэгчийн зөвшөөрөл.....	20
<b>ЗУРГААДУГААР БҮЛЭГ</b> .....	<b>21</b>
<b>АГААРЫН НАВИГАЦИ</b> .....	<b>21</b>
39 дүгээр зүйл. Агаарын навигацийн үйлчилгээний байгууллага .....	21
40 дүгээр зүйл. Агаарын навигацийн үйлчилгээ .....	21
41 дүгээр зүйл. Нислэгийн хөдөлгөөний зохицуулалт .....	22

42 дугаар зүйл. Нислэгийн зөрчил.....	22
43 дугаар зүйл. Аюул тулгарсан агаарын хөлөг.....	22
<b>ДОЛООДУГААР БҮЛЭГ.....</b>	<b>22</b>
<b>АЭРОДРОМ, НИСЭХ БУУДАЛ.....</b>	<b>22</b>
44 дугаар зүйл. Аэродром, нисэх буудал байгуулах.....	22
45 дугаар зүйл. Аэродром орчмын аюулгүйн бүс.....	23
46 дугаар зүйл. Дохио, тэмдэг.....	23
47 дугаар зүйл. Аэродром, нисэх буудлын үйл ажиллагаанд хориглох зүйл.....	23
48 дугаар зүйл. Аэродром, нисэх буудлын өмчлөл.....	23
<b>НАЙМДУГААР БҮЛЭГ.....</b>	<b>24</b>
<b>НИСЭХИЙН АЮУЛГҮЙН ХАМГААЛАЛТ.....</b>	<b>24</b>
49 дүгээр зүйл. Нисэхийн аюулгүйн хамгаалалтын байгууллага.....	24
50 дугаар зүйл. Аюулгүйн үзлэг.....	24
51 дүгээр зүйл. Байгууламжийн хамгаалалт.....	24
<b>ЕСДҮГЭЭР БҮЛЭГ.....</b>	<b>24</b>
<b>АГААРЫН ХӨЛГИЙН НИСЛЭГИЙН ТОХИОЛДЛЫГ.....</b>	<b>24</b>
<b>ШИНЖЛЭН ШАЛГАХ.....</b>	<b>24</b>
52 дугаар зүйл. Агаарын хөлгийн ослыг шинжлэн шалгах алба.....	24
53 дугаар зүйл. Нислэгийн тохиолдлыг шинжлэн шалгах.....	25
54 дүгээр зүйл. Ерөнхий шинжлэн-шалгагч, түүний бүрэн эрх.....	26
55 дугаар зүйл. Шинжлэн-шалгагч, түүний бүрэн эрх.....	26
56 дугаар зүйл. Шинжлэн шалгах багийн ахлагч, түүний бүрэн эрх.....	26
57 дугаар зүйл. Шинжлэн шалгах ажиллагааны тайлан.....	27
58 дугаар зүйл. Аюулгүй байдлын зөвлөмж.....	27
59 дүгээр зүйл. Шинжлэн шалгах ажиллагааг сэргээх.....	28
<b>АРАВДУГААР БҮЛЭГ.....</b>	<b>28</b>
<b>БУСАД ЗҮЙЛ.....</b>	<b>28</b>
60 дугаар зүйл. Хууль тогтоомж зөрчигчдөд хүлээлгэх хариуцлага.....	28

**ИРГЭНИЙ НИСЭХИЙН ТУХАЙ**  
**/Шинэчилсэн найруулга/**

**НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ**

**1 дүгээр зүйл. Хуулийн зорилт**

1.1. Энэ хуулийн зорилт нь Монгол Улсын иргэний нисэхийн үйл ажиллагааны эрх зүйн үндсийг тогтоож, Монгол Улсын агаарын зайд иргэний агаарын хөлгөөр нислэг үйлдэх, нислэгийн аюулгүй байдлыг хангахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

**2 дугаар зүйл. Иргэний нисэхийн тухай хууль тогтоомж**

2.1. Иргэний нисэхийн тухай хууль тогтоомж нь Үндсэн хууль, энэ хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

2.2. Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

**3 дугаар зүйл. Иргэний нисэхийн үйл ажиллагааны үндсэн зарчим**

3.1. Иргэний нисэхийн үйл ажиллагаа нь аюулгүй, үр ашигтай, хүртээмжтэй байх зарчмыг баримтална.

**4 дүгээр зүйл. Хуулийн үйлчлэх хүрээ**

4.1. Энэ хуулиар дараахь харилцааг зохицуулна:

4.1.1. Монгол Улсын иргэний нисэхийн үйл ажиллагаа;

4.1.2. Монгол Улсын нутаг дэвсгэрт байрлаж байгаа буюу Монгол Улсын агаарын зайд нислэг үйлдэж байгаа агаарын хөлгийн үйл ажиллагаа;

4.1.3. Монгол Улсын нутаг дэвсгэрийн гадна нислэг үйлдэж байгаа Монгол Улсын бүртгэлтэй болон Монгол Улсын агаарын тээвэрлэгчийн агаарын хөлгийн үйл ажиллагаа;

4.1.4. нислэгийн аюулгүй байдлын хяналт, зохицуулалтын үйл ажиллагаа;

4.1.5. агаарын хөлгийн нислэгийн тохиолдлыг шинжлэн шалгах ажиллагаа.

4.2. Монгол Улсын хяналттай агаарын зайд нислэг үйлдэж байгаа улсын агаарын хөлгийн байлдааны үүргийн нислэгээс бусад нислэгийн хөдөлгөөнийг зохицуулна.

4.3. Монгол Улсын нутаг дэвсгэрт онц болон дайны байдал зарласан үед иргэний нисэхийн үйл ажиллагааг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохицуулна.

**5 дугаар зүйл. Хуулийн нэр томъёоны тодорхойлолт**

5.1. Энэ хуульд хэрэглэсэн дараахь нэр томъёог доор дурдсан утгаар ойлгоно:

5.1.1. “агаарын зай” гэж Монгол Улсын нутаг дэвсгэр дээгүүр нислэг үйлдэх агаарын орон зайг;

5.1.2. “агаарын зам” гэж агаарын хөлгийн нислэгийг аюулгүйгээр гүйцэтгэхэд зориулсан өндөр ба өргөнөөр хязгаарлагдсан агаарын зайг;

- 5.1.3. “агаарын навигацийн байгууламж” гэж гэрэлтүүлэг, радио чиглүүлэгч, цаг агаарын мэдээ дамжуулах, радио холбоо, ажиглалтын болон агаарын хөлгийн нислэгийн хөдөлгөөнийг удирдах, хянахад ашигладаг төхөөрөмж, байгууламжийг;
- 5.1.4. “агаарын навигацийн үйлчилгээ” гэж агаарын хөлгийг нислэгийн бүх үе шатанд нислэгийн хөдөлгөөний зохицуулалт, холбоо, навигацийн ажиглалт, цаг уур, эрэн хайх болон нисэхийн мэдээллийн үйлчилгээгээр хангах цогц үйл ажиллагааг;
- 5.1.5. “агаарын тээвэрлэгч” гэж иргэний нисэхийн холбогдох дүрмийн дагуу олгосон агаарын тээвэрлэгчийн гэрчилгээ эзэмшигчийг;
- 5.1.6. “агаарын тээвэрлэгчийн гэрчилгээ” гэж агаарын тээврийн үйл ажиллагаа эрхлэх эрх олгосон баримт бичгийг;
- 5.1.7. “агаарын хөлгийн дарга” гэж агаарын хөлгөөр үйл ажиллагаа эрхлэгчийн томилсон, тухайн агаарын хөлгийн үйл ажиллагаа, нислэгийн аюулгүй байдлыг хариуцсан нисгэгчийг;
- 5.1.8. “агаарын хөлөг” гэж агаарын өгсөх урсгалын нөлөөллөөр бус, өөрөө агаартай харилцан үйлчилсний хүчинд агаарт тогтож, хөдөлгөөн хийж чадах аливаа төхөөрөмжийг;
- 5.1.9. “агаарын хөлгөөр нислэгийн үйл ажиллагаа эрхлэгч” гэж агаарын тээврийн болон ерөнхий зориулалтын нисэхийн үйл ажиллагаа эрхлэгчийг;
- 5.1.10. “аэродром” гэж агаарын хөлгийн хөөрөлт, буулт болон гадаргуу дээрх хөдөлгөөнд ашиглахад зориулан газар, эсхүл усан дээр байгуулсан талбай болон байгууламжийг;
- 5.1.11. “аэродром орчмын аюулгүйн бүс” гэж аэродромыг байгуулахдаа нислэгийн аюулгүй байдлыг хангах зайлшгүй шаардлагыг үндэслэн тогтоосон аэродром орчмын газар, эсхүл усан гадаргуу, агаарын орон зайг;
- 5.1.12. “аюул тулгарсан агаарын хөлөг” гэж агаарын хөлөг, түүнд байгаа хүмүүст аюултай байж болзошгүй, эсхүл тусламж шаардлагатай нөхцөл байдалд орсон агаарын хөлгийг;
- 5.1.13. “Аюулгүй байдлын зөвлөмж” гэж шинжлэн шалгах ажиллагааны үр дүнд, эсхүл аюулгүй байдлын талаар гаргасан судалгаа болон төрөл бүрийн эх үүсвэрээс үндэслэн агаарын хөлгийн ослоос урьдчилан сэргийлэх зорилгоор Агаарын хөлгийн ослыг шинжлэн шалгах албанаас гаргасан баримт бичгийг;
- 5.1.14. “аюултай бараа” гэж агаараар тээвэрлэхэд хүний эрүүл мэнд, аюулгүй байдал, эд хөрөнгө, эсхүл хүрээлэн буй орчинд эрсдэл учруулж болох Олон улсын иргэний нисэхийн байгууллагын Техникийн зааварчилгаанд заасан эд зүйлс, бодисыг;
- 5.1.15. “багийн гишүүн” гэж нислэгийн үед агаарын хөлөгт үүрэг гүйцэтгэхээр томилогдсон ажилтныг;
- 5.1.16. “бүртгэгч улс” гэж агаарын хөлгийг бүртгэсэн улсыг;
- 5.1.17. “зорчигч” гэж
- 1/ агаарын тээврийн үйл ажиллагааны хувьд тээвэрлэлтийн гэрээний дагуу агаарын хөлөгт зорчиж байгаа;

2/ ерөнхий зориулалтын нисэхийн хувьд агаарын хөлөгт зорчиж байгаа, багийн гишүүдээс бусад этгээдийг.

5.1.18. “инцидент” гэж Чикагогийн конвенци түүний Хавсралт 13-т тодорхойлсноор ослоос бусад агаарын хөлгийн ашиглалтын үйл ажиллагаатай холбоотой аюулгүй байдалд нөлөөлсөн, нөлөөлж болзошгүй нислэгийн тохиолдлыг;

5.1.19. “Иргэний агаарын хөлөг” гэж улсын агаарын хөлгөөс бусад бүх төрлийн агаарын хөлгийг;

5.1.20. “Иргэний нисэхийн дүрэм” гэж Чикагогийн конвенцийн Хавсралтуудад нийцүүлэн боловсруулж, баталсан дүрмийг;

5.1.21. “иргэний нисэхийн үйл ажиллагаа” гэж агаарын хөлгийн нислэгийн үйл ажиллагаа болон түүнд дэмжлэг үзүүлэх иргэний нисэхийн бусад үйл ажиллагаа, үйлчилгээг;

5.1.22. “иргэний нисэхийн үйлчилгээний байгууллага” гэж агаарын навигаци, аэродром болон нисэхийн аюулгүйн хамгаалалтын үйлчилгээний байгууллагыг;

5.1.23. “маягийн гэрчилгээ” гэж агаарын хөлгийн хийц нь нислэгт тэнцэх чадварын холбогдох шаардлагад нийцэж байгааг Хэлэлцэн тохирогч улсын эрх бүхий байгууллагаас тодорхойлж олгосон баримт бичгийг;

5.1.24. “Монреалийн конвенци” гэж Монгол Улсын 2004 онд нэгдэн орсон Олон улсын агаарын тээвэрт хамаарах зарим журмыг нэг мөр болгох тухай 1999 оны конвенцийг;

5.1.25. “зохицуулалттай агаарын зай” гэж агаарын хөлөг хөөрөлт, буултыг аюулгүй гүйцэтгэхэд шаардлагатай орон зайг багтаасан, нислэгийн нам өндрөөс хяналттай агаарын зайн дээд хязгаар хүртэлх агаарын зайг;

5.1.26. “нислэгт тэнцэх чадвар” гэж агаарын хөлөг аюулгүй нисэх, аюулгүй ажиллах чадамжийг;

5.1.27. “нисэх баг” гэж нислэгийн хугацаанд агаарын хөлөгт нисгэгч, эсхүл нисэх-инженерийн үүрэг гүйцэтгэхээр томилсон ажилтныг;

5.1.28. “нисэх буудал” гэж иргэний нисэхийн дүрмийн дагуу гэрчилгээжсэн аэродром, нисэхийн үйлчилгээний барилга байгууламж бүхий цогцолборыг;

5.1.29. “нисэхийн аюулгүйн хамгаалалт” гэж Чикагогийн конвенцийн Хавсралт 17-д тодорхойлсны дагуу иргэний нисэхийг хөндлөнгийн хууль бус үйлдлээс хамгаалах цогц арга хэмжээг;

5.1.30. “нисэхийн мэргэшсэн ажилтан” гэж иргэний нисэхийн дүрмийн дагуу Иргэний нисэхийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын Даргын олгосон үнэмлэх, гэрчилгээ эзэмшигчийг;

5.1.31. “нотлох баримт” гэж шинжлэн шалгах ажиллагаатай холбоотой захидал харилцаа, санамж бичиг, заавар, журам, газрын зураг, бүдүүвч зураглал, гэрэл зураг, ярианы бичлэг, дүрс бичлэг, цахим файл, нислэгийн өгөгдлийн болон бүхээгийн яриа бичигч, тэдгээрийн хуулбар болон бусад баримт сэлтийг;

- 5.1.32. “нислэгийн аюулгүй байдал” гэж иргэний нисэхийн үйл ажиллагааг хүний амь нас, эрүүл мэнд болон эд хөрөнгөд хохирол учруулах эрсдэлгүй гүйцэтгэх нөхцөл болон чадварыг;
- 5.1.33. “нислэг” гэж агаарын хөлөг нислэг үйлдэх зорилгоор зогсоолоос хөдлөхөөс эхлэн хөөрөх, газарт бууж хөдөлгөөнөө бүрэн зогсоох хүртэлх үйл явцыг;
- 5.1.34. “нислэгийн ажилтан” гэж нисгэгч, багийн гишүүн, инженер техникийн болон нислэгийн үйл ажиллагааны ажилтныг;
- 5.1.35. “нислэгийн тохиолдол” гэж агаарын хөлгийн нислэгийн үйл ажиллагаатай холбоотой осол болон инцидентийг;
- 5.1.36. “осол” гэж Чикагогийн конвенцийн Хавсралт 13-т тодорхойлсон нислэгийн тохиолдлуудыг;
- 5.1.37. “олон улсын нислэг” гэж хоёр болон түүнээс дээш улсын агаарын зайд үйлдэх нислэгийг;
- 5.1.38. “орох, гарах цэг” гэж улсын хилийг агаарын замаар нэвтрэх газар зүйн байршлыг;
- 5.1.39. “Олон улсын иргэний нисэхийн байгууллага” гэж Чикагогийн конвенцийн дагуу 1944 онд байгуулагдсан, Канад улсын Монреаль хотод төвтэй, Нэгдсэн үндэстний байгууллагын иргэний нисэхийн төрөлжсөн байгууллагыг;
- 5.1.40. “улсын агаарын хөлөг” гэж цэрэг, цагдаа, хил хамгаалах, гаалийн болон төрийн бусад чиг үүргийг хэрэгжүүлэх агаарын хөлгийг;
- 5.1.41. “Хамтын ажиллагааны зохицуулалт” гэж нисэхийн бүтээгдэхүүн болон эрх зүйн баримт бичгийг хүлээн зөвшөөрөх зорилгоор Хэлэлцэн тохирогч улсын иргэний нисэхийн эрх бүхий байгууллагатай байгуулсан гэрээг;
- 5.1.42. “Хэлэлцэн тохирогч улс” гэж Олон улсын иргэний нисэхийн тухай Чикагогийн конвенцид нэгдэн орсон улсыг;
- 5.1.43. “Чикагогийн конвенци” гэж Монгол Улс 1989 оны 9 дүгээр сарын 07-ны өдөр нэгдэн орсон Олон улсын иргэний нисэхийн тухай 1944 оны 12 дугаар сарын 07-ны өдөр Чикаго хотноо батлагдсан олон улсын конвенци болон түүний Хавсралтуудыг;
- 5.1.44. “шинжлэн шалгах” гэж нислэгийн тохиолдлоос урьдчилан сэргийлэх зорилгоор мэдээлэл цуглуулах, дүн шинжилгээ хийх, нөлөөлсөн хүчин зүйл бүрийг тогтоож, дүгнэлт гарган, Аюулгүй байдлын зөвлөмж гаргах үйл ажиллагааг;
- 5.1.45. “шинжлэн шалгах багийн ахлагч” гэж Чикагогийн конвенцийн Хавсралт 13-ын дагуу шинжлэн шалгах ажиллагааг удирдах, хянах, гүйцэтгэхээр томилогдсон шинжлэн шалгагчийг;
- 5.1.46. “эдийн засгийн зохицуулалтын дүрэм” гэж иргэний нисэхийн арилжааны үйл ажиллагааг зохицуулах зорилгоор боловсруулж, баталсан эрх зүйн баримт бичгийг;
- 5.1.47. “эдийн засгийн зөвшөөрөл” гэж нийгмийн хэрэгцээ шаардлагыг хангах зорилгоор эрх бүхий этгээдээс агаарын тээвэрлэгчид энэ хуулийн дагуу олгосон зөвшөөрлийг;

5.1.48. “хувийн нислэг” гэж агаарын хөлөг эзэмшигч хувийн зорилгоор өөрөө тухайн нислэгт оролцож буй, арилжааны бус нислэгийн үйл ажиллагааг;

5.2. Иргэний нисэхийн үйл ажиллагаанд хэрэглэдэг бусад нэр томъёог иргэний нисэхийн дүрмийн нэр томъёоны тайлбарт зааснаар ойлгоно.

## **ХОЁРДУГААР БҮЛЭГ.**

### **ИРГЭНИЙ НИСЭХИЙГ ТӨРӨӨС ЗОХИЦУУЛАХ**

#### **6 дугаар зүйл. Улсын Их Хурлын бүрэн эрх**

- 6.1. Улсын Их Хурал иргэний нисэхийн талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:
- 6.1.1. иргэний нисэхийн тухай хууль тогтоомжийг батлах, хэрэгжилтэд нь хяналт тавих;
  - 6.1.2. иргэний нисэхийн асуудлаар олон улсын гэрээнд Монгол Улс нэгдэн орох, гарах асуудлыг шийдвэрлэх;
  - 6.1.3. хуульд заасан бусад бүрэн эрх.

#### **7 Засгийн газрын бүрэн эрх**

- 7.1. Засгийн газар иргэний нисэхийн талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:
- 7.1.1. Олон улсын иргэний нисэхийн тухай Чикагогийн конвенцид заасан онц бүрэн эрхийг Монгол Улсын агаарын зайд хэрэгжүүлэх;
  - 7.1.2. иргэний нисэхийн салбарыг хөгжүүлэх талаар төрөөс баримтлах бодлогыг тодорхойлох;
  - 7.1.3. нисэхийн аюулгүйн хамгаалалтын үндэсний бодлогыг тодорхойлох;
  - 7.1.4. иргэний нисэхийн тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах;
  - 7.1.5. Засгийн газар хоорондын агаарын харилцааны болон бусад хэлэлцээрийг батлах;
  - 7.1.6. иргэний нисэхийн салбарт хэрэгжүүлэх үндэсний хөтөлбөрийг батлах;
  - 7.1.7. иргэний нисэхийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын Дарга бөгөөд Ерөнхий байцаагчийг томилох, чөлөөлөх;
  - 7.1.8. агаарын тээврийн зайлшгүй үйлчилгээнд татаас олгох асуудлыг шийдвэрлэх;
  - 7.1.9. олон улсын нисэх буудал байгуулах, татан буулгах асуудлыг шийдвэрлэх;
  - 7.1.10. хуульд заасан бусад бүрэн эрх.

#### **8 дугаар зүйл. Төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрх**

8.1. Иргэний нисэхийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

- 8.1.1. Иргэний нисэхийн салбарын хөгжлийн бодлогыг боловсруулах, хэрэгжилтийг зохицуулах;

- 8.1.2. Иргэний нисэхийн салбарт хэрэгжүүлэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг нэгдсэн удирдлагаар хангах, хэрэгжилтэд хяналт тавих;
- 8.1.3. Иргэний нисэхийн эдийн засгийн зохицуулалтыг хэрэгжүүлэх, хэрэгжилтэд хяналт тавих;
- 8.1.4. Засгийн газар хоорондын агаарын харилцааны болон бусад хэлэлцээрийг байгуулах.

## **9 дүгээр зүйл. Сайд, түүний бүрэн эрх**

9.1. Иргэний нисэхийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн бөгөөд Сайд нь дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

- 9.1.1. Энэ хуулийн хэрэгжилтэд хяналт тавих;
- 9.1.2. нислэгийн аюулгүй байдал, нисэхийн аюулгүйн хамгаалалтын хэрэгжилтийг хангуулах;
- 9.1.3. Олон улсын иргэний нисэхийн байгууллагын зөвлөмжид нийцүүлэн иргэний нисэхийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын зохион байгуулалтын бүтэц, орон тоог батлах;
- 9.1.4. Монгол Улсад агаарын тээвэрлэгчийн хариуцлагын даатгалын бодлогыг, тодорхойлох;
- 9.1.5. агаарын навигацийн болон иргэний нисэхийн үйлчилгээний хураамжийг батлах;
- 9.1.6. Агаарын хөлгийн ослыг шинжлэн шалгах албаны дарга бөгөөд Ерөнхий шинжлэн шалгагчийг томилох, чөлөөлөх;
- 9.1.7. Агаарын хөлгийн ослыг шинжлэн шалгах албаны зохион байгуулалтын бүтэц, орон тоо, үйл ажиллагааны болон шинжлэн шалгах ажиллагааны дүрмийг батлах;
- 9.1.8. шаардлагатай бол агаарын хөлгийн ослыг шинжлэн шалгах ажиллагааг Хэлэлцэн тохирогч улсын агаарын хөлгийн ослыг шинжлэн шалгах байгууллагатай хамтран гүйцэтгэх, эсхүл тухайн байгууллагад хэсэгчлэн, буюу бүрэн шилжүүлэх асуудлыг шийдвэрлэх;
- 9.1.9. энэ хуулийн 20 дугаар зүйлд заасан иргэний нисэхийн дүрмийг батлах;
- 9.1.10. энэ хуулийн 34 дүгээр зүйлд заасан эдийн засгийн зохицуулалтын дүрмийг батлах;
- 9.1.11. агаарын тээврийн үйл ажиллагаа эрхлэх эдийн засгийн зөвшөөрөл олгох;
- 9.1.12. олон улсын нислэг үйлдэх агаарын тээвэрлэгчийг томилох, нислэгийн шугамыг хуваарилах;
- 9.1.13. иргэний нисэхийн салбарын ажилтнуудын хөдөлмөрийн нөхцөл, мэргэжлийн онцлогийг харгалзан нэмэгдэл цалин хөлс, тэтгэмж олгох, нийгмийн баталгааг хангахтай холбоотой асуудлыг шийдвэрлэх;
- 9.1.14. шинжлэн шалгагч, иргэний нисэхийн хяналтын байцаагч болон ажилтны дундаж цалин нь салбарын адилтгах мэргэжлийн ажилтны цалингийн дундаж хэмжээтэй дүйцэхүйц байхаар тогтмол шийдвэрлэх;



9.1.15. хуульд заасан бусад.

9.2. Сайд агаарын навигацийн хураамжийн орлогын найм хүртэл хувийг хууль тогтоомжийн хүрээнд иргэний нисэхийн хяналт, зохицуулалт, эдийн засгийн зохицуулалт, агаарын хөлгийн ослыг шинжлэн шалгах ажиллагаа, төрийн өмчит нисэх буудал болон нисэхийн хамгаалалтын үйлчилгээнд захиран зарцуулна.

9.3. Сайд энэ зүйлийн 9.2-т заасан чиг үүргийг хэрэгжүүлэх байгууллагын төсөв, навигацийн хураамжийн орлогын хуваарилалтыг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнтэй хамтран батална.

9.4. Сайд энэ хуулийн 9.1.2-т заасан бүрэн эрхээ Иргэний нисэхийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын Даргад гэрээгээр, тодорхой хугацаатай шилжүүлэн гүйцэтгүүлж болох ба шилжүүлсэн эрхийн хязгаарлалтыг гэрээнд тодорхой заана.

9.5. Сайд энэ хуулийн 9.2-т заасны дагуу бүрэн эрхээ шилжүүлсэн нь түүнийг нислэгийн аюулгүй байдлын талаар хүлээх хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болохгүй.

### **10 дүгээр зүйл. Төрийн захиргааны байгууллагын бүрэн эрх**

10.1. Иргэний нисэхийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь иргэний нисэхийн хяналт, зохицуулалтыг хэрэгжүүлэх үүрэг бүхий Засгийн газрын тохируулагч агентлаг мөн.

10.2. Иргэний нисэхийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

10.2.1. Олон улсын иргэний нисэхийн байгууллагын стандарт, зөвлөмжийг суурь түвшинд хэрэгжүүлэх;

10.2.2. Хэлэлцэн тохирогч улстай нислэгийн аюулгүй байдлын хяналтын үүрэг, хариуцлага хуваалцах гэрээ байгуулах болон хамтын ажиллагааны зохицуулалт хийх;

10.2.3. Хэлэлцэн тохирогч улсын иргэний нисэхийн байгууллагуудтай харилцах, мэдээлэл солилцох;

10.3. Иргэний нисэхийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын төсвийг агаарын навигацийн хураамжийн орлогоос санхүүжүүлнэ.

10.4. Иргэний нисэхийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь иргэний нисэхийн хяналтын байцаагчийг энэ хуулиар олгогдсон хяналтын чиг үүргээ хэрэгжүүлэхэд шаардлагатай хувцас, хэрэгслээр хангана.

### **11 дугаар зүйл. Дарга, түүний бүрэн эрх**

11.1. Иргэний нисэхийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын Дарга нь энэ хуулиар олгогдсон бүрэн эрхээ үр дүнтэй хэрэгжүүлэхэд шаардлагатай, иргэний нисэхийн салбарт удирдах ажил эрхэлсэн, 15-аас доошгүй жилийн ажлын туршлагатай этгээдийг томилно.

11.2. Дарга нь Монгол Улсын нислэгийн аюулгүй байдал болон иргэний нисэхийн хяналт, зохицуулалтыг бүрэн хариуцна.

11.3. Дарга нь нислэгийн аюулгүй байдлыг хангах зорилгоор иргэний нисэхийн хяналт, зохицуулалтын чиглэлээр дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

- 11.3.1. нийтийн эрх ашигт нийцүүлэн нислэгийн аюулгүй байдлын бодлогыг боловсруулж, хэрэгжүүлэх;
- 11.3.2. иргэний нисэхийн хяналтын байцаагчийг томилох, чөлөөлөх;
- 11.3.3. иргэний нисэхийн дүрэм болон түүний өөрчлөлтийг боловсруулах;
- 11.3.4. зөвлөмжийн цуврал, маягт, бүртгэлийн дэвтэр, ерөнхий заавар, төлөвлөгөө болон техник технологийн баримт бичгийг батлах, тэдгээрт өөрчлөлт оруулах;
- 11.3.5. иргэний нисэхийн үйлчилгээний байгууллагад гэрчилгээ олгох;
- 11.3.6. нисэхийн мэргэшсэн ажилтны үнэмлэх, гэрчилгээ олгох;
- 11.3.7. холбогдох эрх бүхий байгууллагатай зөвшилцөн иргэний нисэхэд ашиглах агаарын зай, агаарын замыг тогтоох;
- 11.3.8. Аюулгүй байдлын зөвлөмжийг үндэслэн нислэгийн тохиолдлоос урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах;
- 11.3.9. нислэгийн аюулгүй байдалд шаардлагатай нөхцөл үүссэн үед, тодорхой хугацаатай Аюулгүй байдлын тушаал гаргаж, нийтэд яаралтай мэдээлэх;
- 11.3.10. агаарын хөлөг, техник үйлчилгээ, сургалтын байгууллага болон агаарын хөлгөөр үйл ажиллагаа эрхлэгч, түүний нислэгийн ажилтанд үзлэг, шалгалт хийх;
- 11.3.11. иргэний нисэхийн үйлчилгээний байгууллага болон тэдгээрийн ажилтнуудад үзлэг, шалгалт хийх;
- 11.3.12. нислэгт тэнцэх чадвараа алдсан агаарын хөлгийн нислэгийг зогсоох, гэрчилгээг түдгэлзүүлэх, хүчингүй болгох;
- 11.3.13. тухайн нислэг нь хүний амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөд хохирол учруулж болзошгүй үед нислэгийг зогсоох хүртэл арга хэмжээг авах;
- 11.3.14. энэ хууль болон иргэний нисэхийн дүрмийн зөрчил нь гэмт хэргийн шинжгүй бол албадан хэрэгжүүлэх журмын дагуу хувь хүн, хуулийн этгээдэд сануулах, торгох, үнэмлэх, гэрчилгээг түдгэлзүүлэх болон хүчингүй болгох арга хэмжээ авах;
- 11.3.15. энэ хуулийн 10.3-т заасан санхүүжилтийг нислэгийн аюулгүй байдлын хяналт, зохицуулалтын үйл ажиллагаа, ажилтнуудын сургалт болон нийгмийн баталгааг хангахад зориулан захиран зарцуулах.
- 11.3.16. үнэмлэх, гэрчилгээ, эрх болон зөвшөөрөл олгох үзлэг, шалгалтын ажлын үнэлгээг тогтоох;
- 11.3.17. хуульд заасан бусад бүрэн эрх.

## **12 дүгээр зүйл. Эрх шилжүүлэх**

12.1. Дарга энэ хуулийн 12.3-т зааснаас бусад, үнэмлэх, гэрчилгээ олгох, түдгэлзүүлэх, хүчингүй болгох эрхээ бусдад шилжүүлэхийг хориглоно.

12.2. Дарга энэ хуулийн 11.3.3, 11.3.8, 11.3.10 болон 11.3.11-д заасан эрхээ иргэний нисэхийн хяналтын байцаагч, ажилтан болон зохих ёсоор мэргэшсэн хувь хүнд гэрээгээр бүхэлд нь, эсхүл хэсэгчлэн шилжүүлж болно.

12.3. Дарга хэт хөнгөн агаарын хөлгийн нислэгийн ажилтан, шүхэрчин, шүхрийн техникчийн үнэмлэх, гэрчилгээ олгох эрхийг нисэх клуб болон шүхрийн үйл ажиллагаа эрхлэгч этгээдэд шилжүүлж болно.

12.4. Гэрээнд тухайн шилжүүлсэн эрхийн хязгаарлалт болон хугацааг тодорхой заана.

12.5. Дарга эрхээ шилжүүлсэн нь түүнийг нислэгийн аюулгүй байдлыг хангахтай холбогдох хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болохгүй.

### **13 дугаар зүйл. Хяналтын байцаагч, түүний бүрэн эрх**

13.1. Иргэний нисэхийн хяналтын байцаагч мэргэжлээрээ багшийн, эсхүл шалгагчийн зэрэглэл эзэмшдэг, эсхүл агаарын хөлгийн нислэгийн аюулгүй байдалтай холбоотой шийдвэр гаргах ажил үүргийг 5-аас доошгүй жил гүйцэтгэсэн дадлага туршлагатай, нисэхийн мэргэшсэн ажилтан байна.

13.2. Иргэний нисэхийн хяналтын байцаагч энэ хууль, иргэний нисэхийн дүрэм, зааврын хүрээнд иргэний нисэхийн хяналт, зохицуулалтыг хэрэгжүүлнэ.

13.3. Иргэний нисэхийн хяналтын байцаагч нь дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

13.3.1. нислэгт тэнцэх чадвартай, нислэгийн үйл ажиллагаа нь энэ хууль, иргэний нисэхийн дүрэм болон Чикагогийн конвенцийн холбогдох Хавсралтын шаардлагыг хангаж байгааг бататгах зорилгоор Монгол Улсад нислэгийн үйл ажиллагаа гүйцэтгэж байгаа агаарын хөлөгт аль ч үед саадгүй нэвтрэх;

13.3.2. аль улсад нислэг гүйцэтгэж байгаагаас үл хамааран, нислэгт тэнцэх чадвартай, нислэгийн үйл ажиллагаа нь энэ хууль, иргэний нисэхийн дүрмийн шаардлагыг хангаж байгааг бататгах зорилгоор Монгол Улсын бүртгэлтэй, эсхүл Монгол Улсын агаарын тээвэрлэгчийн ашиглаж байгаа агаарын хөлөгт аль ч үед саадгүй нэвтрэх;

13.3.3. энэ хууль болон иргэний нисэхийн дүрмийн шаардлагыг хангаж байгааг бататгах зорилгоор дараахь иргэний нисэхийн барилга байгууламжид аль ч үед саадгүй нэвтрэх:

13.3.3.1. агаарын тээвэрлэгчийн ажлын байр;

13.3.3.2. ангар;

13.3.3.3. техник үйлчилгээний байгууллага;

13.3.3.4. засвар, үйлчилгээний газар;

13.3.3.5. агаарын хөлгийн зогсоол;

13.3.3.6. аэродром;

13.3.3.7. агаарын навигацийн үйлчилгээний байгууламж;

13.3.3.8. шатахуун хадгалах, түгээх байгууламж;

13.3.3.9. ачааны байгууламж;

13.3.3.10. нисэхийн сургалтын байгууллага.

13.3.4. хяналт шалгалтын ажилд шаардлагатай мэдээ, судалгаа, тайлбар, тодорхойлолт, бусад баримт бичгийг холбогдох иргэн, хуулийн этгээдээс шаардан гаргуулж авах;

13.3.5. Даргаас гэрээгээр шилжүүлсэн бусад бүрэн эрх.

#### **14 дугаар зүйл. Хяналт, зохицуулалтын үйл ажиллагаа**

14.1. Иргэний нисэхийн хяналт, зохицуулалт нь нислэгийн аюулгүй байдлын болон иргэний нисэхийн үйлчилгээний хяналт, зохицуулалтаас бүрдэнэ.

14.2. Нислэгийн аюулгүй байдлын хяналт, зохицуулалтад дараахь зохицуулалт хамаарна:

14.2.1. нисэхийн мэргэшсэн ажилтны үнэмлэх, гэрчилгээ;

14.2.2. агаарын хөлгийн бүртгэл, нислэгт тэнцэх чадвар;

14.2.3. нислэгийн үйл ажиллагаа.

14.3. Иргэний нисэхийн үйлчилгээний хяналт, зохицуулалтад дараахь зохицуулалт хамаарна:

14.3.1. агаарын навигацийн үйлчилгээ;

14.3.2. аэродром, нисэх буудал;

14.3.3. нисэхийн аюулгүйн хамгаалалт.

14.4. Иргэний нисэхийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь иргэний нисэхийн хяналт, зохицуулалтыг тасралтгүй, үр дүнтэй хэрэгжүүлэхэд шаардлагатай хүний нөөц, санхүүгийн чадавхтай байна.

#### **15 дүгээр зүйл. Нисэхийн мэргэшсэн ажилтны үнэмлэх, гэрчилгээ**

15.1. Иргэний нисэхийн дүрэмд заасан мэргэжил, туршлага, болон эрүүл мэндийн шаардлага хангасан хүсэлт гаргагчид нисэхийн мэргэшсэн ажилтны үнэмлэх, эрүүл мэндийн гэрчилгээ олгоно.

15.2. Үнэмлэх гэрчилгээнд нислэгийн аюулгүй байдлыг хангахад зайлшгүй шаардлагатай эрх, хязгаарлалтыг заасан байна.

15.3. Нисэхийн мэргэшсэн ажилтан нь энэ хууль, иргэний нисэхийн дүрэм болон тухайн үнэмлэх, гэрчилгээний эрхийн хүрээнд ажиллана.

#### **16 дугаар зүйл. Техник үйлчилгээний байгууллага**

16.1. Агаарын хөлөг, түүний бүрдэл хэсэгт үйлчилгээ, их засвар, өөрчлөлт хийх Техник үйлчилгээний байгууллага нь иргэний нисэхийн дүрмийн дагуу эрх бүхий байгууллагаас гэрчилгээжсэн байна.

16.2. Хэлэлцэн тохирогч улсын эрх бүхий байгууллагаар гэрчилгээжсэн агаарын хөлгийн техник үйлчилгээний байгууллагад холбогдох иргэний нисэхийн дүрмийн дагуу үзлэг, шалгалт хийж, шаардлага хангасан бол хүлээн зөвшөөрч болно.

16.3. Монгол Улсад бүртгэлтэй агаарын хөлөг, түүний бүрдэл хэсгийн техник үйлчилгээг дараахь байгууллага гүйцэтгэнэ:

16.3.1. энэ хуулийн 16.1-ын дагуу гэрчилгээжсэн;

16.3.2. нисэхийн бүтээгдэхүүн үйлдвэрлэгч;

16.3.3. Хэлэлцэн тохирогч улсын эрх бүхий байгууллагаар гэрчилгээжсэн болон хамтын ажиллагааны зохицуулалтаар хүлээн зөвшөөрөгдсөн.

16.4. Техник үйлчилгээний байгууллага нь агаарын хөлөг, түүний бүрдэл хэсгийн техник үйлчилгээ болон засварыг гэрчилгээний эрх, хязгаарлалтын хүрээнд, техникийн болон үйл ажиллагааны батлагдсан зааврын дагуу гүйцэтгэх үүрэгтэй.

16.5. Техник үйлчилгээний байгууллага нь тухайн гэрчилгээнд заасан үйлчилгээг гүйцэтгэхэд шаардлагатай бүтэц, инженер, техникийн ажилтан болон барилга байгууламж, төхөөрөмжтэй байна.

### **17 дугаар зүйл. Сургалтын байгууллага**

17.1. Нислэгийн болон агаарын хөлөг, түүний бүрдэл хэсгийн техник үйлчилгээ, их засварын сургалт явуулах байгууллага нь иргэний нисэхийн дүрмийн дагуу эрх бүхий байгууллагаас гэрчилгээжсэн байна.

17.2. Сургалтын байгууллага нь гэрчилгээний эрх, хязгаарлалтын хүрээнд, батлагдсан сургалтын хөтөлбөрийн дагуу сургалтын үйл ажиллагааг зохион байгуулах үүрэгтэй.

17.3. Сургалтын байгууллага нь тухайн гэрчилгээнд заасан сургалтыг зохион байгуулахад шаардлагатай бүтэц, мэргэжлийн багшлах бүрэлдэхүүн, сургалтын хөтөлбөр, агаарын хөлөг, дадлагажуур болон сургалтын төхөөрөмжтэй байна.

### **18 дүгээр зүйл. Хэлэлцэн тохирогч улсын нисэхийн баримт бичиг**

18.1. Хэлэлцэн тохирогч улсын иргэний нисэхийн эрх бүхий байгууллагаас олгосон үнэмлэх, гэрчилгээг дараахь нөхцөлд хүлээн зөвшөөрч болно:

18.1.1. нислэгт тэнцэх чадварын гэрчилгээ, нислэгийн ажилтны үнэмлэх нь Чикагогийн Конвенцийн шаардлагад нийцсэн, түүнд байнгын хяналт тавьдаг бол;

18.1.2. агаарын тээвэрлэгчийн гэрчилгээ нь Чикагогийн Конвенцийн шаардлагад нийцсэн түүнд байнгын хяналт тавьдаг бол.

18.2. Хэлэлцэн тохирогч улсаас олгосон мэргэжлийн үнэмлэх, эрүүл мэндийн гэрчилгээг тухайн ажилтны мэргэжил, эрүүл мэндийн хувьд ажил үүрэг гүйцэтгэх чадвартай болохыг нотлох баримтаар тооцож болно.

## **ГУРАВДУГААР БҮЛЭГ.**

### **ИРГЭНИЙ НИСЭХИЙН ДҮРЭМ**

#### **19 дугаар зүйл. Иргэний нисэхийн дүрмийн зохицуулалт**

19.1. Нислэгийн аюулгүй байдалтай холбоотой иргэний нисэхийн үйл ажиллагааг энэ хуульд нийцүүлэн гаргасан иргэний нисэхийн дүрмээр зохицуулна.

19.2. Иргэний нисэхийн дүрмийн зохицуулалт нь иргэний нисэхийн дүрэм, зөвлөмжийн цуврал, маягт болон бүртгэлийн дэвтрээс бүрдэнэ.

#### **20 дүгээр зүйл. Иргэний нисэхийн дүрмээр зохицуулах үйл ажиллагаа**

20.1. Иргэний нисэхийн дүрмээр иргэний нисэхийн нислэгийн аюулгүй байдалтай холбоотой дараахь харилцааг зохицуулна:

20.1.1. иргэний нисэхийн дүрмийн нэр томъёоны тайлбар;

20.1.2. нислэгийн тохиолдлыг мэдээлэх;

20.1.3. албадан хэрэгжүүлэх арга хэмжээ;

20.1.4. агаарын хөлөг, бүтээгдэхүүн, эд ангийн гэрчилгээжүүлэх, агаарын хөлгийн бүртгэл, нислэгт тэнцэх чадварын удирдамж болон, техник үйлчилгээ;

20.1.5. аюулгүй байдлын удирдлагын тогтолцоо;

20.1.6. нисэхийн мэргэшсэн ажилтны үнэмлэх, зэрэглэл, эрүүл мэндийн гэрчилгээжүүлэх;

20.1.7. агаарын зайг тогтоох, ангилах болон агаарын зайн зохицуулалт;

20.1.8. нислэгийн үйл ажиллагааны ерөнхий дүрэм, хэрэглэлийн нислэгийн журам;

20.1.9. хүнгүй агаарын хөлөг, аргамжаат шүхэр болон хүнгүй агаарын хөлгөөр үйл ажиллагаа эрхлэгчийг гэрчилгээжүүлэх;

20.1.10. шүхэр, хэт хөнгөн агаарын хөлөг болон нисэх клубийг гэрчилгээжүүлэх;

20.1.11. том, дунд, жижиг агаарын хөлгийн нислэгийн үйл ажиллагаа болон дотоод, гадаадын агаарын тээвэрлэгчийг гэрчилгээжүүлэх;

20.1.12. агаарын тээвэрлэгчийн аюулгүйн хамгаалалтын хөтөлбөр болон нисэхийн аюулгүйн хамгаалалтын үйлчилгээний байгууллагыг гэрчилгээжүүлэх;

20.1.13. нисдэг тэргээр дүүжин ачаа тээвэрлэх, хөдөө аж ахуйн агаарын хөлөг болон чөлөөт нисэхийн үйл ажиллагааг гэрчилгээжүүлэх;

20.1.14. агаарын хөлөг зохион бүтээх, үйлдвэрлэх болон техник үйлчилгээний байгууллагыг гэрчилгээжүүлэх;

20.1.15. нислэгийн ажилтны сургалтын байгууллагыг гэрчилгээжүүлэх;

20.1.16. агаарын хөлгөөр аюултай бараа тээвэрлэх болон зохицуулалттай агаарын ачааны байгууллагыг гэрчилгээжүүлэх;

20.1.17. аэродром байгуулах болон аэродромын үйл ажиллагааг, гэрчилгээжүүлэх;

20.1.18. агаарын навигацийн техник үйлчилгээ, нислэгийн хөдөлгөөний үйлчилгээ, хэрэглэлийн нислэгийн журам зохиох, нисэхийн цаг уурын болон нисэхийн мэдээллийн үйлчилгээний байгууллагыг гэрчилгээжүүлэх;

20.1.19. үнэмлэх, зэрэглэл, гэрчилгээ олгох үзлэг, шалгалтын хураамжийг тогтоох;

20.1.20. иргэний нисэхийн дүрмээр зохицуулах шаардлагатай бусад үйл ажиллагаа.

20.2. Иргэний нисэхийн дүрэм нь олон улсын иргэний нисэхийн баримт бичгийг хэрэглэх, ашиглахад хялбар байх зорилгоор ижил бүтэц, дугаарлалттай байна.

## **21 дугаар зүйл. Иргэний нисэхийн дүрмийн шаардлагаас чөлөөлөх**

21.1. Иргэний нисэхийн дүрмийн шаардлагаас Дарга дараахь нөхцөлд чөлөөлж, болно:

21.1.1. хүсэлт гаргагч дүрмийн тухайн шаардлагыг хүлээн зөвшөөрч болохуйц өөр хэлбэрээр хангаж байгаа бол;

21.1.2. хүсэлт гаргагчийн хэрэгжүүлэхээр санал болгосон арга хэмжээ нь дүрмийн тухайн шаардлагыг хэрэгжүүлснээс илүү үр дүнтэй бол;

21.1.3. тухайн дүрмийн шаардлагаас чөлөөлөх нь нислэгийн аюулгүй байдалд сөргөөр нөлөөлөхгүй болох нь тогтоогдсон бол.

21.2. Иргэний нисэхийн дүрмийн шаардлагаас чөлөөлөх үйл ажиллагааг зохицуулах журмыг Дарга баталж мөрдөнө.

21.3. Иргэний нисэхийн дүрмийн шаардлагаас чөлөөлсөн шийдвэрийг нийтэд мэдээлнэ.

## **22 дугаар зүйл. Иргэний нисэхэд гадаад хэл хэрэглэх**

22.1. Иргэний нисэхэд ашиглах техникийн баримт бичгийг монгол, англи болон маягийн гэрчилгээг хүлээн зөвшөөрсөн улсын хэл дээр хэрэглэж болно.

22.2. Агаарын навигацийн үйлчилгээнд монгол, англи хэл хэрэглэх ба шаардлагатай үед харилцан бүрэн ойлголцох өөр хэл хэрэглэж болно.

## **ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ**

### **АГААРЫН ХӨЛӨГ, ТҮҮНД ХАМААРАХ ҮЙЛ АЖИЛЛАГАА**

## **23 дүгээр зүйл. Агаарын хөлгийн бүртгэл**

23.1. Иргэний нисэхийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь агаарын хөлгийн үндэсний харъяаллыг тодорхойлох бүртгэлийн тогтолцоотой байна.

23.2. Монгол Улсын иргэн, хуулийн этгээд өөрийн өмчлөл, эзэмшилд байгаа, бусад улсад бүртгэлгүй агаарын хөлгийг иргэний нисэхийн дүрмийн дагуу Монгол Улсад бүртгүүлнэ.

23.3. Монгол Улс болон гадаад улсад бүртгэлгүй агаарын хөлгөөр Монгол Улсын агаарын зайд нислэг үйлдэхийг хориглоно.

23.4. Энэ хууль болон Иргэний нисэхийн дүрмийг зөрчсөн, эсхүл нийтийн ашиг сонирхолд сөргөөр нөлөөлөх нөхцөл үүссэн нөхцөлд Дарга агаарын хөлгийн бүртгэлийн гэрчилгээг түдгэлзүүлэх, эсхүл хүчингүй болгоно.

23.5. Агаарын хөлгийн бүртгэлийн гэрчилгээ нь тухайн агаарын хөлгийн үндэсний харъяаллыг гэрчлэх ба агаарын хөлгийн өмчлөлийг нотлохгүй.

## **24 дүгээр зүйл. Агаарын хөлгийн эзэмшил, өмчлөл**

24.1. Иргэний нисэхийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь Монгол Улсад бүртгэлтэй агаарын хөлөг, хөдөлгүүр, сэнс болон бусад эд ангийн эзэмшигч, өмчлөгчийн бүртгэлийн тогтолцоог бүрдүүлсэн байна.

24.2. Энэ хуулийн 24.1-д заасан бүртгэлд ороогүй, Монгол Улсын бүртгэлтэй агаарын хөлөг, хөдөлгүүр, сэнс болон бусад эд ангийн эзэмшил, өмчлөлийн баримт бичгийг хүчингүйд тооцно.

## **25 дугаар зүйл. Агаарын хөлгийн нислэгт тэнцэх чадвар**

25.1. Даргын хүлээн зөвшөөрсөн агаарын хөлгийн маягийг Монгол Улсад нислэгийн үйл ажиллагаанд ашиглаж болно.

25.2. Агаарын хөлгийг үйлдвэрлэгч улсын эрх бүхий байгууллагатай хамтын ажиллагааны зохицуулалт хийснээр тухайн агаарын хөлгийн маягийг хүлээн зөвшөөрч болно.

25.3. Монгол Улсад бүртгэлтэй агаарын хөлгийг эзэмшигч нь нислэгт тэнцэх чадварын гэрчилгээ авах хүсэлтийг Даргад гаргана.

25.4. Маягийн гэрчилгээний шаардлага хангасан, үзлэг, шалгалтаар нислэгийн аюулгүй байдлын хангаж байгаа нь тогтоогдсон агаарын хөлөгт нислэгт тэнцэх чадварын гэрчилгээ олгоно.

25.5. Нислэгт тэнцэх чадварын гэрчилгээнд түүний хүчинтэй хугацаа, агаарын хөлгийн зориулалт, нислэгийн аюулгүй байдлыг хангахад шаардлагатай ангилал, хязгаарлалт болон бусад мэдээллийг заана.

## **26 дугаар зүйл. Нислэгийн үйл ажиллагааны төрөл**

26.1. Нислэгийн үйл ажиллагаа нь агаарын тээврийн болон ерөнхий зориулалтын нисэхийн үйл ажиллагаанаас бүрдэнэ.

## **27 дугаар зүйл. Агаарын тээврийн үйл ажиллагаа**

27.1. Агаарын тээврийн үйл ажиллагаа гэж агаараар зорчигч, ачааг төлбөртэй тээвэрлэх агаарын тээвэрлэгчийн гэрчилгээ эзэмшигчийн дараахь үйл ажиллагааг ойлгоно.

27.1.1. 30-аас дээш зорчигчийн суудалтай том нисэх онгоцны;

27.1.2. 10-30 зорчигчийн суудалтай дунд нисэх онгоцны;

27.1.3. нисдэг тэрэг, эсхүл 9 ба түүнээс доош зорчигчийн суудалтай нисэх онгоцны;

27.1.4. агаарын харилцааны хэлэлцээрийн дагуу томилогдсон гадаад улсын агаарын тээвэрлэгчийн хуваарьт нислэгийн.

## **28 дүгээр зүйл. Ерөнхий зориулалтын нисэхийн үйл ажиллагаа**

28.1. Ерөнхий зориулалтын нисэхийн үйл ажиллагаа нь тусгай зориулалтын нисэх, чөлөөт нисэх, нисэх клуб болон хувийн нислэгийн үйл ажиллагаанаас бүрдэнэ.

28.2. Тусгай зориулалтын нисэхийн үйл ажиллагаанд дараахь үйл ажиллагаа хамаарна:

28.2.1. аглаг газарт нисдэг тэргээр, эсхүл 9 ба түүнээс доош зорчигчийн суудалтай нисэх онгоцоор зорчигч, барааг хөлс, шан урамшуулалтай тээвэрлэх ерөнхий зориулалтын агаарын тээвэрлэгчийн гэрчилгээ эзэмшигчийн үйл ажиллагаа;

28.2.2. нисдэг тэргээр дүүжин ачаа тээвэрлэх;

28.2.3. хөдөө аж ахуйн агаарын хөлгийн үйл ажиллагаа.

28.3. Чөлөөт нисэхийн үйл ажиллагаанд шүхэр, агаарын бөмбөлөг, хэт хөнгөн, хөнгөн агаарын хөлгөөр зорчигчийг хөлс, шан урамшуулалтай тээвэрлэх үйл ажиллагаа хамаарна.



28.4. Нисэх клуб болон хувийн нислэгийн үйл ажиллагаа эрхлэгч нь дараахь шаардлагыг хангасан байна. Үүнд:

28.4.1. нислэгт тэнцэх чадварын шаардлага хангасан агаарын хөлөгтэй байх;

28.4.2. хүчинтэй үнэмлэх, гэрчилгээ эзэмшдэг нислэгийн ажилтантай байх;

28.4.3. үйл ажиллагаандаа тохирсон ерөнхий заавар, журамтай байх.

28.5. Нисэх клуб болон хувийн нислэгийн үйл ажиллагаа эрхлэгч нь нислэгийн аюулгүй байдлыг бүрэн хариуцна.

28.6. Нисэх клуб болон хувийн нислэгийн үйл ажиллагааг зардал хуваах хэлбэрээр гүйцэтгэж болно.

28.7. Ерөнхий зориулалтын нисэхийн үйл ажиллагаанд энэ хууль болон иргэний нисэхийн дүрмээс давсан хориг, хязгаарлалт тогтоохыг хориглоно.

### **29 дугаар зүйл. Агаарын тээвэрлэгчийн гэрчилгээ**

29.1. Энэ хуулийн 35.1-ийн дагуу олгосон агаарын тээврийн эдийн засгийн зөвшөөрөл бүхий Монгол Улсын иргэн, хуулийн этгээд агаарын тээвэрлэгчийн гэрчилгээ эзэмших хүсэлт гаргана.

29.2. Энэ хууль болон холбогдох иргэний нисэхийн дүрмийн шаардлага хангасан Монгол Улсын иргэн, хуулийн этгээдэд агаарын тээврийн үйл ажиллагаа эрхлэх дараахь гэрчилгээг олгож болно.

29.2.1. агаарын тээвэрлэгчийн гэрчилгээ;

29.2.2. ерөнхий зориулалтын агаарын тээвэрлэгчийн гэрчилгээ.

29.3. Эдийн засгийн зөвшөөрөл бүхий гадаадын агаарын тээвэрлэгч энэ хууль болон иргэний нисэхийн дүрмийн шаардлагыг хангасан нөхцөлд түүнд гадаадын агаарын тээвэрлэгчийн гэрчилгээ олгож болно.

29.4. Агаарын тээвэрлэгчийн гэрчилгээ нь түдгэлзүүлэх, хүчингүй болгох хүртэл хүчинтэй байна.

29.5. Шинээр агаарын тээврийн үйл ажиллагаа эрхлэх Монгол Улсын иргэн, хуулийн этгээдэд агаарын тээвэрлэгчийн гэрчилгээг тусгай нөхцөлтэйгөөр 1 жилийн хугацаатай олгож болно.

29.6. Агаарын тээвэрлэгчийн гэрчилгээг бусдад шилжүүлэхийг хориглоно.

### **30 дүгээр зүйл. Агаарын тээвэрлэгчийн үүрэг**

30.1. Монгол Улсад үйл ажиллагаа явуулж буй агаарын тээвэрлэгч нь дараахь үүрэгтэй:

30.1.1. нислэгийн үйл ажиллагааг гэрчилгээний эрх, хязгаарлалт болон үйл ажиллагааны тодорхойлолтын хүрээнд гүйцэтгэх;

30.1.2. иргэний нисэхийн дүрмийн шаардлага хангасан удирдлага, зохион байгуулалтын бүтэцтэй байх;

30.1.3. үйл ажиллагаандаа тохирсон агаарын хөлөг болон хангалттай тооны нислэгийн ажилтантай байх;

30.1.4. ашиглаж байгаа агаарын хөлөг болон түүний эд ангийн үзлэг, засвар үйлчилгээг гэрчилгээний эрх, хязгаарлалтын хүрээнд гүйцэтгэх;

30.1.5. нислэгийн тохиолдол давтан гарахаас урьдчилан сэргийлэх зорилгоор дотоод шинжлэн шалгах ажиллагааг гүйцэтгэх;

30.1.6. аюултай барааг иргэний нисэхийн дүрэм болон Олон улсын иргэний нисэхийн байгууллагын Техникийн зааварчилгааны дагуу тээвэрлэх.

### **31 дугаар зүйл. Агаарын хөлгийн даргын бүрэн эрх**

31.1. Агаарын хөлгөөр үйл ажиллагаа эрхлэгч нь нислэгийн аюулгүй байдлыг хангах зорилгоор тухайн нислэгийн үйл ажиллагааг гүйцэтгэхэд шаардлагатай үнэмлэх, гэрчилгээтэй нисгэгчийг агаарын хөлгийн даргаар томилох үүрэгтэй.

31.2. Нислэгийн аюулгүй байдлыг хангах, хүний амь нас, эд хөрөнгийг хамгаалах зорилгоор агаарын хөлгийн даргын өгсөн зааварчилгааг багийн гишүүд болон зорчигчид дагаж мөрдөх үүрэгтэй.

31.3. Агаарын хөлгийн дарга агаарын хөлөг, багийн бусад гишүүд болон зорчигчдын аюулгүй байдлыг хангах зорилгоор тухайн нислэгийн үйл ажиллагаатай холбоотой эцсийн шийдвэр гаргах эрхтэй.

31.4. Агаарын хөлгийн дарга дараахь онцгой нөхцөлд иргэний нисэхийн дүрэмд зааснаас өөр шийдвэр гаргах эрхтэй:

31.4.1. хүний амь нас, эд хөрөнгөд аюул тулгарсан бол;

31.4.2. иргэний нисэхийн дүрмийн шаардлагыг мөрдөх нь тухайн онцгой нөхцөлийг хүндрүүлэхээр бол;

31.5. Агаарын хөлгийн дарга энэ зүйлд заасан онцгой нөхцөлийн үед иргэний нисэхийн дүрэмд зааснаас өөр шийдвэр гаргасан бол энэ тухай агаарын навигацийн үйлчилгээний байгууллагад нэн даруй мэдэгдэх үүрэгтэй.

31.6. Агаарын хөлгийн дарга онцгой нөхцөлтэй холбоотойгоор иргэний нисэхийн дүрмийг зөрчсөн бол энэ тухай тайланг Даргад бичгээр хүргүүлэх үүрэгтэй.

31.7. Агаарын хөлгийн дарга нислэгийн аюулгүй байдалд сөргөөр нөлөөлж болох үйлдэл гаргасан зорчигчийн үйлдлийг таслан зогсооход чиглэсэн арга хэмжээ авах үүрэгтэй.

31.8. Гадаад улсын агаарын зайд нислэг үйлдэж байгаа агаарын хөлгийн дарга нь албадан саатуулагдах нөхцөл байдалд орсон тохиолдолд тухайн улсын эрх бүхий байгууллагаас тавьсан шаардлагыг дагаж мөрдөх үүрэгтэй.

### **32 дүгээр зүйл. Нислэгийн үйл ажиллагаанд хориглох зүйлс**

32.1. Нислэгийн үйл ажиллагаанд дараахь зүйлийг хориглоно:

32.1.1. бүртгэлгүй, эсхүл нислэгт тэнцэх чадварын шаардлага хангаагүй агаарын хөлгөөр, эсхүл нисэх эрхгүй этгээд гүйцэтгэх;

32.1.2. нислэгт тэнцэх чадварын шаардлага хангаагүй агаарын хөлөг, түүний эд ангийг нислэгийн үйл ажиллагаанд ашиглах;

32.1.3. агаарын хөлөгт гарал үүсэл нь тодорхойгүй, үйлдвэрлэгчийн техникийн тодорхойлолтод нийцээгүй эд анги ашиглах;

32.1.4. иргэний нисэхийн дүрэм, үнэмлэх гэрчилгээний эрх, хязгаарлалтыг зөрчин нислэгийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа агаарын хөлөг, түүний бүрдэл хэсэгт техник үйлчилгээ хийх;

32.1.5. агаарын хөлөгтэй холбоотой ажил, үйлчилгээнд нислэгийн ажилтны үнэмлэх, гэрчилгээгүй этгээдийг ажиллуулах, гэрчилгээгээр олгосон эрхээс хэтэрсэн ажил үүрэг гүйцэтгүүлэх;

32.1.6. нислэгийн үед агаарын хөлгийн даргын зөвшөөрөлгүйгээр нисэх багийн бүхээгт нэвтрэх.

### **33 дугаар зүйл. Нислэгийн үеийн хэв журам**

33.1. Нислэгийн үед агаарын хөлгийн багийн гишүүдээс өгсөн зааварчилгааг зорчигч дагаж мөрдөх үүрэгтэй.

33.2. Багийн гишүүн нь нислэгийн үед аюулгүй байдалд сөргөөр нөлөөлж болох үйлдэл гаргасан, гаргахыг завдсан зорчигчийг аюулгүй болгох арга хэмжээ авна.

33.3. Энэ хуулийн 33.2-д заасан хэв журам зөрчсөн зорчигчийг аюулгүй болгох арга хэмжээний журмыг Сайд хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнтэй хамтран батална.

33.4. Агаарын тээвэрлэгч нислэгийн аюулгүй байдалд эрсдэл учруулахуйц хууль бус үйлдэл гаргасан, гаргаж байсан зорчигчийг тээвэрлэхээс татгалзаж болно.

## **ТАВДУГААР БҮЛЭГ.**

### **ИРГЭНИЙ НИСЭХИЙН ЭДИЙН ЗАСГИЙН ЗОХИЦУУЛАЛТ**

#### **34 дугаар зүйл. Эдийн засгийн зохицуулалтын дүрэм**

34.1. Иргэний нисэхийн эдийн засгийн зохицуулалтын дүрмээр дараахь харилцааг зохицуулна:

34.1.1. агаарын тээврийн үйл ажиллагаа эрхлэх эдийн засгийн зөвшөөрөл олгох;

34.1.2. олон улсын агаарын тээвэрлэгчийн томилгоо;

34.1.3. агаарын тээвэрлэгчийн болон нисэхийн үйлчилгээний байгууллагын хариуцлагын даатгал;

34.1.4. тээвэрлэлтийн гэрээ, тээвэрлэлтийн үнэ, тариф, зорчигчийн бүртгэл;

34.1.5. агаарын тээврийн зайлшгүй үйлчилгээнд татаас олгох;

34.1.6. агаарын навигаци, нисэх буудал, аэродромын үйлчилгээ, нисэхийн хамгаалалтын үйлчилгээний хураамжийг тогтоох, зарцуулах;

34.1.7. статистикийн мэдээлэл;

34.1.8. иргэний нисэхийн төлбөртэй үйлчилгээний төрөл, төлбөрийн хэмжээг тогтоох, зарцуулах.

34.3 Эдийн засгийн зохицуулалтын дүрэм нь хэрэглэх, ашиглахад хялбар байх зорилгоор ижил бүтэц, дугаарлалттай байна.

#### **35 дугаар зүйл. Эдийн засгийн зөвшөөрөл**

35.1. Нийгмийн хэрэгцээ шаардлагыг хангах, энэ хуулийн 36 дугаар зүйлд заасан даатгалын бодлогыг хэрэгжүүлэх чадвартай, агаарын тээврийн үйл ажиллагаа эрхлэх

хүсэлт гаргасан Монгол Улсын хуулийн этгээдэд Сайд эдийн засгийн зөвшөөрөл олгож болно.

35.2. Агаарын тээвэрлэгч нь энэ хууль болон иргэний нисэхийн дүрэм, агаарын тээврийн эдийн засгийн зөвшөөрөлд заасан нөхцөл, хязгаарлалтыг зөрчсөн тохиолдолд Сайд тухайн зөвшөөрлийг түдгэлзүүлэх, эсхүл хүчингүй болгоно.

### **36 дугаар зүйл. Агаарын тээвэрлэгчийн хариуцлага**

36.1. Агаарын тээвэрлэгч нь агаарын хөлгийн зорчигч, ачаа, тээш болон гуравдагч этгээдэд учруулсан хохирлын нөхөн олговор олгох зорилгоор хариуцлагын даатгалд хамрагдсан байх үүрэгтэй.

36.2. Олон улсын агаарын тээврийн үйл ажиллагааны үед зорчигч амь насаа алдсан, хүнд гэмтэл авсан, эсхүл ачаа, тээш, шуудан гэмтсэн, алдагдсан болон гуравдагч этгээдэд хохирол учирсан бол Монреалийн конвенцийг дагаж мөрдөнө.

36.3. Агаарын хөлгөөр үйл ажиллагаа эрхлэгч нь албан үүргээ гүйцэтгэж байгаа агаарын хөлгийн багийн гишүүд амь насаа алдсан, эсхүл хүнд гэмтэл авсан нөхцөлд хохирлыг нөхөн төлөх зорилгоор даатгуулсан байх үүрэгтэй.

### **37 дугаар зүйл. Агаарын тээвэрлэгчийн өмчлөл**

37.1. Монгол Улсын агаарын тээвэрлэгчийн өмчийн 51-ээс доошгүй хувийг Монгол Улсын иргэн, эсхүл хуулийн этгээд өмчилнө.

37.2. Агаарын тээвэрлэгч нь өөрийн өмчлөлийн эрхийн талаархи аливаа өөрчлөлтийг эрх бүхий этгээдэд мэдэгдэх үүрэгтэй.

### **38 дүгээр зүйл. Гадаадын агаарын тээвэрлэгчийн зөвшөөрөл**

38.1. Дараахь шаардлага хангасан гадаадын агаарын тээвэрлэгчид Сайд эдийн засгийн зөвшөөрөл олгоно:

38.1.1. гадаадын улсын агаарын тээвэрлэгч нь тухайн улсын Засгийн газрын эрх бүхий байгууллагаас олон улсын агаарын тээврийн үйл ажиллагаа эрхлэхээр Монгол Улстай байгуулсан гэрээний нөхцөлийн дагуу томилогдсон байх;

38.1.2. олон улсын агаарын тээврийн үйл ажиллагааг зохих ёсоор гүйцэтгэх чадвартай, энэ хууль болон иргэний нисэхийн дүрмийн шаардлагыг хангасан байх;

38.1.3. Монреалийн конвенцийн шаардлагыг хангасан хариуцлагын даатгалтай байх;

38.1.4. тухайн зөвшөөрлийг олгох нь Монгол Улсын агаарын тээвэрлэгчийн ашиг сонирхолд харшлахгүй байх.

38.2. Гадаадын агаарын тээвэрлэгч нь энэ хууль, иргэний нисэхийн дүрэм болон энэ зүйлийн 38.1-ын дагуу олгосон эдийн засгийн зөвшөөрлийн эрх, хязгаарлалтыг зөрчсөн бол Сайд тухайн зөвшөөрлийг түдгэлзүүлэх, эсхүл хүчингүй болгоно.

38.3. Эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж байгаа этгээд, энэ хуулийн 38.1-т заасны дагуу олгосон зөвшөөрлийг түдгэлзүүлэх, өөрчлөх, эсхүл хүчингүй болгох хүсэлтийг Сайдад гаргаж болно.

38.4. Гадаадын агаарын тээвэрлэгчийг Монгол Улсын нутаг дэвсгэрийн дотор нэг цэгээс, нөгөө цэгийн хооронд агаарын тээврийн үйл ажиллагаа эрхлэхийг хориглоно.

## **ЗУРГААДУГААР БҮЛЭГ.**

### **АГААРЫН НАВИГАЦИ**

#### **39 дүгээр зүйл. Агаарын навигацийн үйлчилгээний байгууллага**

39.1. Монгол Улсын агаарын зайд агаарын навигацийн үйлчилгээг энэ хуулийн дагуу иргэний нисэхийн дүрмээр гэрчилгээжсэн төрийн өмчит улсын төсөвт агаарын навигацийн үйлчилгээний байгууллага үзүүлнэ.

39.2. Нислэгийн аюулгүй байдлыг хангах зорилгоор агаарын навигацийн үйлчилгээний байгууллага нь Иргэний нисэхийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын харъяанд байна.

39.3. Агаарын навигацийн үйлчилгээний байгууллага нь агаарын навигацийн хураамжийн орлого болон үйл ажиллагааны бусад орлогоос санхүүжнэ.

39.4. Агаарын навигацийн үйлчилгээний байгууллага нь Монгол Улсын агаарын навигацид ашигладаг нислэгийн зураг, газрын гадаргуугийн болон саадын зураг, аэродромын зургийг агуулсан нисэхийн өгөгдлийн нэгдмэл санг бүрдүүлэх үүрэгтэй.

39.5. Монгол Улсын нутаг дэвсгэрт буулгүйгээр дамжин өнгөрөх нислэгт үзүүлсэн агаарын навигацийн үйлчилгээний хураамжийн орлогыг Төрийн санд төвлөрүүлнэ.

#### **40 дүгээр зүйл. Агаарын навигацийн үйлчилгээ**

40.1. Агаарын навигацийн үйлчилгээний байгууллага нь Монгол Улсын нутаг дэвсгэрт дараахь чиг үүргийг хэрэгжүүлнэ:

40.1.1. агаарт эсхүл газар агаарын хөлөг хоорондоо мөргөлдөхөөс сэргийлэн нислэгийн хөдөлгөөнийг зохицуулах;

40.1.2. Аэродромд бусад хөдөлгөөн болон саадтай агаарын хөлөг мөргөлдөхөөс сэргийлэн зохицуулах;

40.1.3. нислэгийн хөдөлгөөний дэс дараалалт шуурхай байдлыг хангах;

40.1.4. нислэгийг аюулгүй, үр ашигтай үйлдэхэд хэрэгцээтэй мэдээллээр хангах;

40.1.5. эрэн хайх, аврах туслах агаарын хөлгийн талаар холбогдох байгууллагад мэдэгдэх, туслалцаа үзүүлэх.

40.2. Монгол Улсын агаарын зайд нислэг үйлдэх замыг холбоо, навигацийн төхөөрөмжөөр нислэгийн аюулгүй байдлыг хангах түвшинд тоногдсон байна.

40.3. Агаарын навигацийн үйлчилгээнд ашигладаг нисэхийн холбоо, навигаци, ажиглалтын төхөөрөмжийн нэгдсэн сүлжээ нь төрийн өмчид байна.

40.4. Нислэгийн аюулгүй байдлыг тасралтгүй хангах зорилгоор төрийн өмчит агаарын навигацийн үйлчилгээний байгууллагад ажил хаялт зохион байгуулахыг хориглоно.

40.5. Агаарын навигацийн үйлчилгээг ерөнхий зориулалтын нисэхийн үйл ажиллагаанд хялбаршуулсан журмаар үзүүлж болно.

#### **41 дүгээр зүйл. Нислэгийн хөдөлгөөний зохицуулалт**

41.1. Монгол Улсын агаарын зайд нислэг үйлдэх агаарын хөлөг нь агаарын навигацийн үйлчилгээний байгууллагын зөвшөөрөлтэй орох, гарах цэгээр нэвтэрч, тогтоосон агаарын замаар нислэг үйлдэх үүрэгтэй.

41.2. Монгол Улсын агаарын зайд үйлдэх нислэгийн хоорондын аюулгүйн зай, агаарын зам, түүний өргөн, өндөр нь олон улсын стандартад нийцсэн байна.

#### **42 дугаар зүйл. Нислэгийн зөрчил**

42.1. Дараахь агаарын хөлгийг нислэгийн зөрчил гаргасан гэж үзнэ:

42.1.1. Монгол Улсын агаарын зайд агаарын навигацийн үйлчилгээний байгууллагын зөвшөөрөлгүй нэвтэрсэн;

42.1.2. Зохицуулалттай агаарын зайд агаарын навигацийн үйлчилгээний байгууллагын зөвшөөрөлгүй нислэг үйлдсэн;

42.1.3. бусад агаарын хөлөгт аюул учруулж болзошгүй нислэг үйлдсэн;

42.1.4. нислэгийн төлөвлөгөөнд заасан, эсхүл зөвшөөрөгдсөн замаас хүндэтгэх шалгаангүйгээр хазайсан.

42.2. Агаарын навигацийн үйлчилгээний байгууллага нь агаарын хөлгийн нисэх багт гаргасан зөрчлийн талаар мэдэгдэж, зөрчлийг таслан зогсоох арга хэмжээ авч, холбогдох эрх бүхий байгууллагад мэдэгдэнэ.

#### **43 дугаар зүйл. Аюул тулгарсан агаарын хөлөг**

43.1. Агаарын навигацийн үйлчилгээний байгууллага Монгол Улсын нутаг дэвсгэрт аюул тулгарсан агаарын хөлгийн талаар зохих журмын дагуу холбогдох байгууллагад нэн даруй мэдэгдэх үүрэгтэй.

43.2. Аюул тулгарсан агаарын хөлөгт тусламж үзүүлэх, эрэн хайх, авран туслах үйл ажиллагааг тухайн агаарын хөлгийг эзэмшигч, эсхүл бүртгэгч улсын эрх бүхий байгууллага Улсын онцгой комисстой хамтран гүйцэтгэнэ.

43.3. Нутгийн захиргааны байгууллага, аж ахуйн нэгж, иргэд аюул тулгарсан агаарын хөлгийн талаар холбогдох байгууллагад нэн даруй мэдээлэх, хүний амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгийг хамгаалах, эмнэлгийн болон бусад зайлшгүй шаардлагатай тусламж үзүүлэх үүрэгтэй.

43.4. Сураггүй алга болсон агаарын хөлгийг эрэн хайх ажиллагааг зогсоох шийдвэрийг Засгийн газар гаргана.

### **ДОЛООДУГААР БҮЛЭГ.**

#### **АЭРОДРОМ, НИСЭХ БУУДАЛ**

#### **44 дүгээр зүйл. Аэродром, нисэх буудал байгуулах**

44.1. Иргэн, хуулийн этгээд нь энэ хууль, иргэний нисэхийн дүрмийн дагуу аэродром байгуулна.

44.2. Олон улсын нисэх буудлыг Засгийн газрын шийдвэрээр байгуулна.

44.3. Агаарын тээврийн тогтмол нислэгийн үйл ажиллагаанд ашигладаг, 30-аас дээш зорчигчийн суудлын багтаамжтай агаарын хөлөгт үйлчлэх аэродром нь иргэний нисэхийн дүрмийн дагуу гэрчилгээжсэн байна.

44.4. Энэ зүйлийн 44.3-т заасан гэрчилгээ эзэмшигч нь нислэгт шаардлагатай аэродромын мэдээллийг Агаарын навигацийн мэдээллийн эмхтгэлд тусгаж, нийтэд мэдээлэх үүрэгтэй.

#### **45 дугаар зүйл. Аэродром орчмын аюулгүйн бүс**

45.1. Нислэгийн аюулгүй байдлыг хангах шаардлагын үүднээс иргэний нисэхийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага харьяалах аймаг, хот, сумын Засаг даргатай хамтарч аэродром орчмын аюулгүйн бүсийг тогтооно.

45.2. Аэродром орчмын аюулгүйн бүсийн ашиглалттай холбогдсон асуудлыг иргэний нисэхийн дүрмээр зохицуулна.

45.3. Аэродромын аюулгүйн бүсэд нислэгийн аюулгүй байдалд харшлах үйлдвэрлэл явуулах, үйлчилгээ эрхлэх жагсаалт, барилга байгууламжийн өндрийн хязгаарлалтыг тогтоох журмыг иргэний нисэхийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын Дарга батална.

45.4. Нутгийн захиргааны байгууллага нь иргэний нисэхийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг харгалзан шаардлагатай бол аэродром байгуулах газар, аюулгүйн бүсийг орон нутгийн тусгай хэрэгцээнд авч болно.

#### **46 дугаар зүйл. Дохио, тэмдэг**

46.1. Агаарын хөлөг хөөрөх, буух, явгалах үед агаарын хөлгийн чиг баримжаа тогтооход зориулсан аюулгүй байдлын дохио, тэмдгийг иргэний нисэхийн дүрэмд заасны дагуу аэродром, түүний орчинд байрлуулна.

46.2. Аэродром орчмын дэвсгэр газарт энэ хуулийн 46.1-д заасан дохио, тэмдэгтэй ижил төстэй зүйл байрлуулахыг хориглоно.

46.3. Барилга байгууламж өмчлөгч буюу эзэмшигч нь агаарын хөлгийн нислэгийн аюулгүй байдлыг хангах зорилгоор уг барилга байгууламж дээр аюулгүй байдлын дохио, тэмдгийг иргэний нисэхийн дүрэмд заасны дагуу байрлуулна.

#### **47 дугаар зүйл. Аэродром, нисэх буудлын үйл ажиллагаанд хориглох зүйл**

47.1. Нисэхийн мэдээллийн эмхтгэлд нийтэд үйлчлэхээр бэлэн байдлыг зарласан аэродром, нисэх буудал нь нислэгийн аюулгүй байдлыг хангах зайлшгүй шаардлагаас бусад үед агаарын хөлөгт үйлчилгээ үзүүлэхээс татгалзах, үйл ажиллагаагаа зогсоохыг хориглоно.

#### **48 дугаар зүйл. Аэродром, нисэх буудлын өмчлөл**

48.1. Олон улсын нислэгт үйлчилдэг эсхүл улсын нислэгтэй хамтран ашигладаг аэродром, нисэх буудал нь төрийн болон орон нутгийн өмчид байна.

**НАЙМДУГААР БҮЛЭГ.**  
**НИСЭХИЙН АЮУЛГҮЙН ХАМГААЛАЛТ**

**49 дүгээр зүйл. Нисэхийн аюулгүйн хамгаалалтын байгууллага**

49.1. Чикагогийн конвенцийн Хавсралт 17-ийн дагуу нисэхийн аюулгүйн хамгаалалтын үйлчилгээг иргэний нисэхийн дүрмийн дагуу гэрчилгээжсэн, төрийн чиг үүргийг хэрэгжүүлэх нисэхийн аюулгүйн хамгаалалтын байгууллага үзүүлнэ.

49.2. Нисэхийн аюулгүйн хамгаалалтын үйлчилгээ нь дараахь үйлчилгээнээс бүрдэнэ:

49.2.1. нисэх буудалд хийх аюулгүйн үзлэг;

49.2.2. нисэх буудал болон агаарын навигацийн байгууламжийн харуул хамгаалалт.

49.3. Нисэхийн аюулгүйн хамгаалалтын байгууллага нь иргэний нисэхийн аюулгүйн хамгаалалтын үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх үүрэгтэй.

49.4. Нисэхийн аюулгүйн хамгаалалтын байгууллага нь аюулгүйн хамгаалалттай холбоотой хууль, тогтоомжийг зөрчсөн этгээдийг эрх бүхий байгууллагад шилжүүлэх зорилгоор саатуулах эрхтэй.

49.5. Олон улсын нисэх буудал нь нисэхийн аюулгүйн хамгаалалтын үйлчилгээгээр хангагдсан байна.

**50 дүгээр зүйл. Аюулгүйн үзлэг**

50.1. Нисэхийн аюулгүйн хамгаалалтын байгууллага нь олон улсын нислэг үйлдэх агаарын хөлөгт нэвтрэн орох аливаа этгээд болон тээвэрлэх ачаа, тээш, шууданд галт зэвсэг, тэсрэх бодис болон агаараар тээвэрлэхийг хориглосон бусад эд зүйлсийг илрүүлэх зорилгоор аюулгүйн үзлэг хийнэ.

50.2. Аюулгүйн үзлэг хийлгэхээс татгалзсан этгээдийг нисэх буудлын аюулгүйн хамгаалалтын бүсэд нэвтрүүлэхийг хориглоно.

50.3. Аюулгүйн үзлэг хийх шаардлагатай нисэх буудлын жагсаалтыг Сайд батална.

**51 дугаар зүйл. Байгууламжийн хамгаалалт**

51.1. Олон улсын нисэх буудал болон агаарын навигацийн байгууламж нь нисэхийн аюулгүйн хамгаалалтын үйлчилгээний байгууллагын хамгаалалтад байна.

51.2. Энэ хуулийн 51.1-д заасан харуул хамгаалалт шаардлагатай нисэх буудал болон агаарын навигацийн байгууламжийн жагсаалтыг Сайд батална.

**ЕСДҮГЭЭР БҮЛЭГ.**  
**АГААРЫН ХӨЛГИЙН НИСЛЭГИЙН ТОХИОЛДЛЫГ**  
**ШИНЖЛЭН ШАЛГАХ**

**52 дугаар зүйл. Агаарын хөлгийн ослыг шинжлэн шалгах алба**

52.1. Монгол Улсын нутаг дэвсгэрт гарсан агаарын хөлгийн нислэгийн тохиолдлыг Чикагогийн конвенцийн 13 дугаар хавсралтын дагуу шинжлэн шалгах, ангилах, бүртгэх ажиллагааг Агаарын хөлгийн ослыг шинжлэн шалгах алба гүйцэтгэнэ.



52.2. Агаарын хөлгийн ослыг шинжлэн шалгах алба нь Сайдын дэргэд ажиллана..

52.3. Агаарын хөлгийн нислэгийн тохиолдлыг шинжлэн шалгах ажиллагааны үндсэн зорилго нь нислэгийн тохиолдлоос урьдчилан сэргийлэхэд чиглэх бөгөөд аливаа этгээдийн гэм бурууг тогтоох зорилгогүй байна.

52.4. Шинжлэн шалгах үйл ажиллагаа нь хараат бус, бие даасан байна

52.5. Агаарын хөлгийн ослыг шинжлэн шалгах алба нь энэ хуулиар олгогдсон бүрэн эрхийн хүрээнд шинжлэн шалгах ажиллагаа гүйцэтгэхэд хүрэлцэхүйц хэмжээний төсөвтэй байна.

52.6. Монгол Улсын бүртгэлтэй агаарын хөлөг тус улсын нутаг дэвсгэрийн гадна нислэгийн тохиолдолд өртсөн үед шинжлэн шалгах ажиллагааг олон улсын гэрээ, хэлэлцээрийн дагуу гүйцэтгэж, Монгол Улсын нэрийн өмнөөс Агаарын хөлгийн ослыг шинжлэн шалгах алба оролцож болно.

52.7. Төрийн бусад байгууллага Чикагогийн конвенцийн Хавсралт 13-ын зорилгоор нислэгийн тохиолдлыг шинжлэн шалгах ажиллагааг гүйцэтгэхийг хориглоно.

52.8. Энэ хуулийн 52.6 заалт нь хууль хяналтын болон бусад байгууллага нислэгийн тохиолдлыг энэ хуульд зааснаас өөр зорилгоор шинжлэн шалгах ажиллагаа гүйцэтгэхийг хориглоогүй.

52.9. Агаарын хөлгийн ослыг шинжлэн шалгах алба нь нислэгийн тохиолдолтой холбоотой мэдээллийг цуглуулан дүн шинжилгээ хийж, түүний шалтгаан болон нөлөөлсөн хүчин зүйлийг тогтоон, тайлан гаргана.

52.10. Агаарын хөлгийн ослыг шинжлэн шалгах алба нь нислэгийн аюулгүй байдлыг сайжруулах, урьдчилан сэргийлэх зорилгоор шинжлэн шалгах ажиллагааны аль ч үе шатанд Аюулгүй байдлын зөвлөмж гаргаж болно.

52.11. Агаарын хөлгийн ослыг шинжлэн шалгах албаны шинжлэн шалгагчийг аливаа этгээдийн гэм бурууг тогтоох зорилгоор захиргааны болон иргэн, эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх болон шүүн таслах ажиллагаанд гэрчээр оролцуулахыг хориглоно.

52.12. Шинжлэн шалгах баг нь осол болсон газарт ажиллахад шаардлагатай хамгаалах хувцас хэрэгсэл, төхөөрөмж болон холбоо, тээврийн хэрэгслээр хангагдсан байна.

### **53 дүгээр зүйл. Нислэгийн тохиолдлыг шинжлэн шалгах**

53.1. Агаарын хөлөг өмчлөгч эзэмшигч, нисэхийн үйл ажиллагаа эрхлэгч, агаарын хөлгийн дарга, нисэх багийн гишүүд, аэродром болон агаарын навигацийн үйлчилгээний байгууллагын ажилтан нь нислэгийн тохиолдлын дэлгэрэнгүй мэдээллийг Агаарын хөлгийн ослыг шинжлэн шалгах албанд нэн даруй, боломжит хэлбэрээр өгөх үүрэгтэй.

53.2. Агаарын хөлгийн ослыг шинжлэн шалгах алба нь ослын мэдээллийг хүлээн авмагц шинжлэн шалгах ажиллагааг нэн даруй эхлүүлэх үүрэгтэй.

53.3. Нислэгийн тохиолдолд өртсөн агаарын хөлөгтэй холбоотой баримт, нотолгоог агаарын хөлөг өмчлөгч эзэмшигч болон холбогдох бусад этгээд шинжлэн шалгах ажиллагааг гүйцэтгэж дуусах хүртэл хадгалж, хамгаалах үүрэгтэй.

53.4. Монгол Улсын нутаг дэвсгэр дээр агаарын хөлгийн осол гарсан үед иргэн, нутгийн захиргааны байгууллага, онцгой байдлын газар, цагдаа болон зэвсэгт хүчний

анги салбарууд Агаарын хөлгийн ослыг шинжлэн шалгах албаны үйл ажиллагаанд шаардлагатай туслалцааг үзүүлэх үүрэгтэй.

#### **54 дугаар зүйл. Ерөнхий шинжлэн шалгагч, түүний бүрэн эрх**

54.1. Агаарын хөлгийн ослыг шинжлэн шалгах албыг Ерөнхий шинжлэн шалгагч удирдах бөгөөд Сайдад ажлаа тайлагнана.

54.2. Ерөнхий шинжлэн-шалгагч нь энэ хуулиар олгогдсон бүрэн эрхээ үр дүнтэй хэрэгжүүлэхэд шаардлагатай иргэний нисэхийн салбарт удирдах ажил эрхэлсэн 15-аас доошгүй жилийн туршлагатай байна.

54.3. Ерөнхий шинжлэн шалгагч дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

54.3.1. Агаарын хөлгийн ослыг шинжлэн шалгах албаны ажилтан, шинжлэн-шалгагчийг томилох, чөлөөлөх;

54.3.2. нислэгийн тохиолдлыг шинжлэн шалгах багийн ахлагч болон гишүүдийг томилох;

54.3.3. нислэгийн тохиолдлыг шинжлэн шалгах ажиллагааг зохион байгуулах;

54.3.4. ослын газрыг хамгаалалтад авах асуудлыг эрх бүхий байгууллагад тавьж шийдвэрлүүлэх;

54.3.5. шинжлэн шалгах ажиллагааны эцсийн тайланг батлах;

54.3.6. агаарын хөлгийн ослыг шинжлэн шалгах албаны төсвийг хууль тогтоомжийн дагуу захиран зарцуулах;

54.3.7. Шинжлэн шалгах ажиллагаанд мөрдөх дотоод үйл ажиллагааны заавар, журмыг батлах.

#### **55 дугаар зүйл. Шинжлэн шалгагч, түүний бүрэн эрх**

55.1. Шинжлэн шалгагч нь агаарын тээврийн нисгэгчийн зэрэглэлтэй нисгэгч, агаарын хөлгийн инженер, мэргэжилтэй байна. Мөн шинжлэн шалгагчийн сургалтад хамрагдсан нислэгийн хөдөлгөөний удирдлагын чиглэлээр ажилласан дадлага туршлага бүхий боловсон хүчин байж болно.

55.2. Шинжлэн шалгагч нь дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

55.2.1. албан үүргээ гүйцэтгэхдээ нислэгийн тохиолдолтой холбоотой нотлох баримт, барилга байгууламжид аль ч үед саадгүй нэвтрэх;

55.2.2. шинжлэн шалгах ажиллагаанд шаардлагатай мэдээ, судалгаа, тодорхойлолт болон бусад нотлох баримтыг холбогдох хувь хүн, хуулийн этгээдээс шаардан авах;

55.2.3. Ерөнхий шинжлэн шалгагчаас олгосон бусад эрх.

#### **56 дугаар зүйл. Шинжлэн шалгах багийн ахлагч, түүний бүрэн эрх**

56.1. Шинжлэн шалгах багийн ахлагч нь дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

56.1.1. Нислэгийн тохиолдол болсон газарт аль ч үед саадгүй нэвтрэх, шинжлэн шалгах ажиллагаанд хамааралтай ослын үлдэгдэл, бүх төрлийн эд зүйлст хяналтаа бүрэн тогтоох;

56.1.2. нислэгийн бичлэгийн төхөөрөмж, тухайн нислэгийн үйл ажиллагаатай холбоотой агаарын навигацийн үйлчилгээний бичлэгүүд зэрэг бусад нотлох баримтыг өөрийн хяналтад авах;

56.1.3. шинжлэн шалгах ажиллагааг цаг алдалгүй эхлүүлэх зорилгоор холбогдох эд мөрийн баримт, агаарын хөлөг, түүний бүрдэл хэсгийн үлдэгдлийг өөрийн хяналтад авах;

56.1.4. шинжлэн шалгах ажиллагааны явцад эд мөрийн баримтыг хамгаалах, агаарын хөлөг, түүний үлдэгдэл байгаа бүсэд зөвшөөрөлгүй этгээд нэвтрэх, эд зүйл үрэгдэж гэмтэх, алдагдахаас хамгаалах боломжит бүх арга хэмжээг авах;

56.1.5. ослын газрыг хамгаалалтад авах зорилгоор эрх бүхий байгууллагад хандаж шийдвэрлүүлэх;

56.1.6. шинжлэн шалгах ажиллагааг гүйцэтгэхэд шаардлагатай ажиглагч, оролцогчийг томилох;

56.1.7. шинжлэн шалгах ажиллагааны явцыг ерөнхий шинжлэн шалгагчид илтгэх, ослын боломжит шалтгаан, нөлөөлсөн байж болох хүчин зүйлд тулгуурлан Аюулгүй байдлын зөвлөмж гаргах ажиллагааг зохион байгуулах;

56.1.8. ослын газрын хамгаалалтыг буулгах, шинжлэн шалгах ажиллагаанд цаашид шаардлагагүй болсон агаарын хөлөг, түүний бүрдэл хэсэг, эд зүйлсийг хадгалалтаас чөлөөлөх;

56.1.9. шинжлэн шалгах ажиллагааны тайлангийн төслийг гаргах;

56.1.10. хууль тогтоомжоор олгосон бусад бүрэн эрх.

### **57 дугаар зүйл. Шинжлэн шалгах ажиллагааны тайлан**

57.1. Агаарын хөлгийн ослыг шинжлэн шалгах алба нь эцсийн тайланг гаргахаас өмнө тухайн ослын шинжлэн шалгах ажиллагаанд хамааралтай байгууллага, хамтран оролцсон улс болон эрх бүхий байгууллагуудаас санал авахаар тайлангийн төслийг хүргүүлнэ.

57.2. Агаарын хөлгийн ослыг шинжлэн шалгах алба нислэгийн тохиолдол давтан гарахаас урьдчилан сэргийлэх зорилгоор шинжлэн шалгах ажиллагааны тайланг боломжит богино хугацаанд гаргана.

57.3. Нууц мэдээллийг нээлттэй болгох нь шинжлэн шалгах ажиллагаанд ач холбогдолтой болохыг эрх бүхий байгууллага тогтоосноос бусад үед, шинжлэн шалгах ажиллагааны тайлангийн төсөл, нотлох баримтыг хуульд зааснаас өөр зорилгоор зөвшөөрөлгүйгээр задруулах, түгээхийг хориглоно.

57.4. Агаарын хөлгийн ослыг шинжлэн шалгах ажиллагааны тайлан болон Аюулгүй байдлын зөвлөмжийг аливаа этгээдийн гэм бурууг тогтоох зорилгоор захиргааны хариуцлага хүлээлгэх, хянан шийдвэрлэх болон шүүн таслах ажиллагаанд нотлох баримтаар ашиглахгүй.

### **58 дүгээр зүйл. Аюулгүй байдлын зөвлөмж**

58.1. Агаарын хөлгийн ослыг шинжлэн шалгах алба нислэгийн аюулгүй байдлыг сайжруулах, урьдчилан сэргийлэх зорилгоор шинжлэн шалгах ажиллагааны аль ч үе шатанд Аюулгүй байдлын зөвлөмж гаргаж болно.

58.2. Аюулгүй байдлын зөвлөмжийг агаарын хөлөг үйлдвэрлэгч, иргэний нисэхийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага болон бусад холбогдох байгууллагад, шаардлагатай бол Олон улсын иргэний нисэхийн байгууллагад хүргүүлнэ.

58.3. Аюулгүй байдлын зөвлөмжийг хүлээн авсан этгээд нь зөвлөмжийн дагуу шаардлагатай арга хэмжээг авч хэрэгжүүлэн хариу мэдэгдэх үүрэгтэй.

58.4. Энэ хуулийн 58.3-т заасан этгээд нь Аюулгүй байдлын зөвлөмжийг хэсэгчлэн, эсхүл бүхэлд нь хүлээн зөвшөөрөхгүй байх бодит үндэслэл байгаа бол тайлбарыг Агаарын хөлгийн ослыг шинжлэн шалгах албанд нэн даруй хүргүүлэх үүрэгтэй.

### **59 дүгээр зүйл. Шинжлэн шалгах ажиллагааг сэргээх**

59.1. Агаарын хөлгийн ослыг шинжлэн шалгах ажиллагааны эцсийн тайлан гарсны дараа тайлангийн дүгнэлтийг өөрчилж болох баримт, нөхцөл байдал шинээр илэрсэн бол Агаарын хөлгийн ослыг шинжлэн шалгах алба шинжлэн шалгах ажиллагааг сэргээх үүрэгтэй.

## **АРАВДУГААР БҮЛЭГ.**

### **БУСАД ЗҮЙЛ**

#### **60 дугаар зүйл. Хууль тогтоомж зөрчигчдөд хүлээлгэх хариуцлага**

60.1. Ерөнхий байцаагч иргэний нисэхийн үйл ажиллагаа эрхлэх үнэмлэх, гэрчилгээ эзэмшигч иргэн, хуулийн этгээдийн энэ хууль болон иргэний нисэхийн дүрмийг зөрчсөн үйлдэл нь санаандгүй, гэмт хэргийн шинжгүй, хүний амь нас, эд хөрөнгөд хохирол учруулаагүй бол зөрчил гаргагчид дараахь арга хэмжээг авна:

60.1.1. сануулах;

60.1.2. торгох;

60.1.3. үнэмлэх, гэрчилгээг түдгэлзүүлэх, эсхүл хүчингүй болгох.

60.2. Үнэмлэх, гэрчилгээнд нь үндэслэлгүйгээр өөрчлөлт оруулсан, түдгэлзүүлсэн, эсхүл хүчингүйд тооцсон шийдвэр гаргасан гэж үзвэл эзэмшигч нь дээд шатны байгууллага, албан тушаалтанд гомдол гаргаж болно.

60.3. Энэ хуулийн 60.2-т заасан гомдлыг хүлээн авсан дээд шатны байгууллага, албан тушаалтан нь Ерөнхий байцаагчийн гаргасан шийдвэрийг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд нягтлан үзэж, тухайн шийдвэрийг хэвээр үлдээх, эсхүл цуцалж дахин өөр шийдвэр гаргана.

60.4. Энэ хуулийн 60.3-т заасан шийдвэрийг хүлээн зөвшөөрөхгүй бол шүүхэд гомдол гаргаж болно.

60.5. Хэрэв энэ хууль болон иргэний нисэхийн дүрмийг зөрчсөн иргэн, хуулийн этгээд нь үнэмлэх, гэрчилгээ эзэмшигч биш бол тухайн зөрчлийг холбогдох хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэнэ.

60.6. Энэ хууль болон иргэний нисэхийн дүрмийг зөрчсөн иргэн, хуулийн этгээдийн үйлдэл нь гэмт хэргийн шинжтэй бол Эрүүгийн хууль болон бусад хууль тогтоомжид заасан хариуцлага хүлээнэ.

## **ГАРЫН ҮСЭГ**